


## НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ

### 1.1.1. Тогтвортой хөгжлийн боловсрол сургалт

- 2021 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан байгууллагуудаас ирүүлсэн Тогтвортой хөгжлийн боловсролын захиалгат сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж, 48 удаа сургалтаар 976 иргэнд үйлчиллээ.
- Мөн Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгын хүрээнд “Цэнхэр алтны ухаалаг хэрэглээ”, “Экологийн ул мөр” сэдвээр видео хичээл бэлтгэж олон нийтэд түгээн, байгууллагын цахим хуудаст байршууллаа.



Зураг. 1


### 1.1.2. Тогтвортой хөгжлийн боловсролын олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа

Олон нийт рүү чиглэсэн нөлөөллийн ажлыг цахимаар зохион байгууллаа. “Хэмнэлттэй, хариуцлагатай иргэн” цахим аяны хүрээнд:

- Тогтвортой хөгжлийн боловсролын “Хариуцлагатай хэрэглээг дэмжих” зорилгын хүрээнд ус, цахилгаанаа хэмнэх, иргэдийн экологийн ул мөрийг бууруулах, хог хаягдлаа ангилан ялгах цахим аян зохион байгууллаа. Нийт 252 иргэн оролцож өөрсдийн сайн жишээгээ бусадтай хуваалцсан сайхан ажил болсон. Энэ ажлаараа усаа хэмнэх, хогоо ангилах, цахилгааны хэрэглээг бууруулах зурган мэдээллийг 7 удаа оруулав. Энэхүү ажлаар
- Цэнхэр алтны ухаалаг хэрэглээ цахим сургалтыг оруулж иргэд олон нийтэд усаа хэрхэн хэмнэх арга, цахим постерыг оруулах
- Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгын хүрээнд ус, тог, цахилгаанаа хэмнэх талаар иргэд олон нийтэд зөвлөгөө мэдээлэл хүргэдэг үлгэр жишээ байгууллагуудын мэдээллийг хэмнэлттэй хариуцлагатай иргэн хаштаг ашиглан байгууллагын цахим хуудаст байршуулах
- Байгууллагын ажилчид байгаль орчинд ээлтэй амьдарч буй өөрсдийн эерэг жишээгээ хэмнэлттэй хариуцлагатай иргэн хаштаг ашиглан олон нийтэд хүргэх
- Хэмнэлттэй хариуцлагатай иргэн гэсэн хүрээгээр байгууллагын бүх ажилчид өөрийн цахим хаягны хүрээг сольж олон нийтийг энэхүү аянд нэгдэхийг уриаллаа.



Зураг. 2



Зураг. 3

### 1.1.3. “Цонхон дээрх тариалан” олон нийт рүү чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа

Олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаагаар 1м.кв аянг явуулах байсан боловч иргэдээс авсан судалгаанд үнэдслэн “Цонхон дээрх тариалан” нөлөөллийн ажлыг зохион байгуулж, Тогтвортой хөгжлийн боловсролын “Зохистой хөдөлмөр ба эдийн засгийг дэмжих” зорилгын хүрээнд байгаль орчноо хамгаалах, эко ногоон орчныг дэмжих, эрүүл хүнсээ өөрсдөө гэрийн нөхцөлд бага зардлаар тарьж ургуулан, хэрэглэх зорилгоор “Монголын ногоон хөгжлийг дэмжих төв”-ийн аграномич Уранбилэгтай хамтарч “Цонхон дээрх тариалан” сургалтыг 2021 оны 5 дугаар сард 239 иргэнд танхим болон цахимаар зохион байгуулж, өөрсдийн хүсэлтээр 1, 2, 3, 11, 15 дугаар хорооны 25 иргэнийг хамруулсан.



Зураг.4



Зураг.5


## ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ ХҮНИЙ ХӨГЖИЛ

### 2.1. Сургалтын үйлчилгээ


#### 2.1.1 Санхүүгийн боловсролын сургалт зохион байгуулах

Санхүүгийн боловсролын хүрээнд:

Санхүүгийн боловсролын Мөнгө түүний үнэ цэн, Хуримтлал, хадгаламж, Өрхийн төсөв, Цахим мөнгөний хэрэглээ зэрэг сэдвээр зохион байгуулсан 38 удаагийн сургалтад 1065 иргэнийг хамруулав. Энэхүү сургалтад Дүүргийн дэргэдэх хэлтэс алба, Нийслэлийн ерөнхий боловсролын 15, 18, 34, 32, 63-р сургуулийн багш ажилчид, 52-р сургуулийн ахлах ангийн сурагчид, 12, 13, 14-р хорооны иргэд хамрагдсан.



Зураг. 6



Зураг. 7

## 2.1.2 Бага санхүүжилтээр өрхийн орлогыг дэмжих сургалт зохион байгуулах

Санхүүгийн боловсролын нэг гол ажил нь “Бага санхүүжилтээр өрхийн орлогоо нэмэгдүүлэх” хөтөлбөрийн хүрээнд гар урлалын /сутаж, декупаж, саван, лаа хийх, сагс сүлжих, даалин урлал/ богино хугацааны онлайн сургалтыг явуулж нийт 33 иргэнд мэргэжлийн чиг баримжаа олголоо.



Зураг. 8



Зураг.9

Мөн “Архигүй, хүчирхийлэлгүй- Аз жаргалтай Монгол гэр бүл” төслийн хүрээнд 4, ТҮК-ийн 10 ажилтан нийт 47 иргэнд сургалт зохион байгуулав.

## 2.1.3 Гэр бүл, эрүүл мэндийн боловсролын сургалт зохион байгуулах

2021 онд Гэр бүл эрүүл, мэндийн боловсрол олгох 65 удаагийн сургалтаар 3225 иргэнд үйлчиллээ. Онцгой байдлын хэлтэс, Гал унтраах, аврах 14, 30, 65-р анги, 230-р цэцэрлэг, Хан-Уул дүүргийн Цагдаагийн 1-р хэлтэс, Нийслэлийн 41, 60, 52-р дунд сургуулийн багш ажилтан, сурагчид оролцож, “Угийн бичиг хэрхэн хөтлөх вэ”, “Сайхан сэтгэлийг өөрөөсөө”, “Бага насны хүүхдэд гэрийн даалгавар хийлгэх зөвлөмж”, “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих арга зүй”, “Гэр бүл төлөвлөлт”, “Хүний сайныг ханилан байж” зэрэг сэдвийн хүрээнд цахим болон танхимаар сургалт авлаа.

## 2.1.4 Эрүүл мэндийн боловсролын сургалт зохион байгуулах

“Нөхөн үржихүй эрүүл мэнд”-ийн өртөөчилсэн сургалтаар ЕБС-иудад “Үе тэнгийн сургагч багш” 12 сурагчийг бэлдэж, хэрэглэгдэхүүн номоор хангалаа.

“Өсвөр насны бэлгийн боловсрол” сэдвээр 6 удаагийн сургалтыг Нийслэлийн 41, 60, 15, 18-р дунд сургуулийн 10, 11 дүгээр ангийн 135 сурагч, ШУТИС-ийн харьяа МСҮТ-ийн 3-4-р дамжааны 528, НТБ-ын зайн сургалтын 85 сурагч, боловсрол нөхөн олгох ангийн сурагчдын 25 эцэг эх, Монгол Германы МСҮТ-ийн 200 оюутан нийт 985 иргэнд зохион байгуулсан.

## 2.1.5 Иргэний эрх зүй улс төрийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагааны хүрээнд чанартай боловсролын үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

Хан-Уул дүүргийн Албан бус Насан туршийн боловсролын төвийн Иргэний эрх зүй, улс төрийн боловсролын агуулгын хүрээнд иргэд болон албан байгууллагуудын албан хаагчдад эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор тогтмол сургалт зохион байгуулагдаж байна.

2021 онд Иргэний эрх зүй, улс төрийн боловсролын агуулгын хүрээнд 88 удаагийн давтамжтай сургалтаар нийт 2774 иргэнд цахим болон танхимаар хүрч үйлчилсэн байна. Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор сургалтыг онлайн сургалтын платформ буюу google meet программ ашиглан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Ажлын байрны бэлгийн дарамт, Нутгийн удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Засаг захиргааны нэгжийн тухай хууль, Авлигын тухай хуулиудаар дүүргийн Хөдөлмөр халамж

үйлчилгээний хэлтэс, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, Хан-Уул дүүргийн 21-р хороо, Удирдлагын академи мөн Нийслэлийн засаг даргын тамгын газар зэрэг байгууллагуудад дээрх сургалтуудыг тус тус хамтран зохион байгууллаа.

### **2.1.6 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах**

Монгол Улсын Засгийн газар Жендэрийн үндэсний хорооноос гаргасан Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд хэрхэн тусгах, хянан шийдвэрлэх талаар арга зүйн зөвлөмжийн дагуу цахим хичээлийг боловсруулан онлайнаар түгээж ажилласан. Мөн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заалт болгон оруулж, багш ажилтнуудад танилцууллаа.

“Ажлын байрны бэлгийн дарамт” сэдэвт хичээлийг 2021 онд Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн харьяа гал унтраах 30, 65, 14-р анги, Цагдаагийн 2 дугаар хэлтсийн 152 албан хаагчдад сургалт явуулав.

“Жендэрт суурилсан хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай” аяны хүрээнд “Жендэрийн хэвшмэл ойлголт”, “Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэхэд иргэн бүрийн оролцоо” сэдвээр 121, 230-р цэцэрлэг, ТҮТ, Дотоод Аудит, Сакура сургууль, АПУ хувьцаат компани зэрэг байгууллагын 852 нийт 1004 иргэнд сургалт зохион байгуулав.

### **2.1.7 Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах талаар**

- Хан-Уул дүүргийн Цагдаагийн 1 хэлтэстэй хамтран 7 хоног бүрийн 1, 3, 5 дахь өдрүүдэд эрүүлжүүлэх байранд хоносон иргэдэд Архины хор уршгийн тухай сургалтыг 125 иргэнийг,
- Цахимын хор хөнөөл хол байх сургалтын 52, 75, 18 дугаар сургуулийн 190 сурагч,
- Архины хамааралтай 200 иргэд,
- ШУТИС-ийн МСҮТ-ийн 1-4 дүгээр дамжааны 442 оюутнуудад “Хорт зуршлаас сэргийлэх” нь сэдвээр сургалт зохион байгуулав.
- Мөн 52 дугаар сургуулийн 7-р ангийн а, б, в бүлгийн 84 сурагчдад “Дэлгэцийн донтолт” сэдвээр сургалт зохион байгуулж 2021 оны байдлаар 1041 иргэнийг хамрууллаа.

### **2.1.8 Харилцаа, ёс зүйн боловсрол олгох сургалт**

Харилцаа, ёс зүйн боловсролын агуулгын хүрээнд 63 удаагийн давтамжтай сургалтаар нийт 2997 иргэнд google meet программ ашиглан явууллаа. Эдгээр сургалтыг Онцгой байдлын алба Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, 18, 21 дүгээр хороо, Нийслэлийн 230, 49, 144, 121, дугаар цэцэрлэг, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, ЕБ-ын 7, 63, 52, 41, 60-р сургууль, Сакура сургууль, Дүүргийн дэргэдэх хэлтэс албадад “Эцэг эхийн харилцаа хүүхдэд хэрхэн нөлөөлдөг вэ?”, “Хамт олны харилцаа”, “Эерэг харилцаа, эерэг хандлага”, “Суралцах ба бүтээлч санаа дэвшүүлэх чадвар”, “Өсвөр насны хүүхдүүдийн хоорондын харилцаа”, “Ёс суртахууны хэм хэмжээ”, “Багаар ажиллах чадвар” зэрэг сэдвүүдээр зохион байгуулав. Цахимаар сургалт явуулахдаа танхимаар зохион байгуулж байсан ээлжит хичээлийн хөтөлбөр, хэрэглэгдэхүүн бүрийг цахимаар зохион байгуулахад бэлтгэн өөрчилж баталгаажуулсан.






График. 1



График. 2

Харилцаа ёс, зүйн боловсролын агуулгын хүрээнд боловсролын хэлтэстэй хамтран эцэг эхчүүдэд зориулсан “Эцэг эхийн харилцаа хүүхдэд хэрхэн нөлөөлдөг вэ?” сэдвээр лайв хичээлийг зохион байгуулсан. Мөн байгууллагын цахим хуудсаар дамжуулан “Эерэг харилцаа хандлага”, “Өсвөр насны хүүхэдтэйгээ харилцах нь”, “Харилцааны соёл”, “Ёс суртахууны хэм хэмжээ” сэдвээр цахим сургалт бэлтгэн олон нийтэд түгээсэн.

### 2.1.9 Мэргэжил сонголт сургалт

2021 онд Good Neighbors Олон Улсын байгууллагатай хамтран Нийслэлийн 41, 60, Сакура сургуулийн ахлах ангийн сурагчдад “Мэргэжлээ хэрхэн зөв сонгох вэ” сэдвээр мэргэжил сонголт хийхэд нь туслалцаа үзүүлэх зорилгоор 6 удаагийн давтамжтайгаар нийт 289 сурагчдад онлайн сургалт зохион байгуулсан байна.




График. 3



График. 4

### 2.1.10 Соёл, гоо зүйн боловсрол олгох сургалтын хүрээнд чанартай боловсролын үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

2021 онд Соёл, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд 78 удаагийн давтамжтайгаар онлайнар google meet программ ашиглан цахим болон танхимаар нийт 2899 иргэнд хүрч үйлчилсэн байна.

Хамтран ажиллах гэрээ байгуулж, сургалтын захиалга өгсөн 230 дугаар цэцэрлэг, Хан-Уул дүүргийн хэлтэс, албадын албан хаагчид, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Улаан загалмайн нийгэмлэг, 52 дугаар сургуулийн багш, сурагчид, Goodneighbours

ОУБ–тай хамтран Нийслэлийн 41 болон 60 дугаар сургуулийн багш, ажилчдад Дижитал минимализм, Биеэ авч явах соёл, Минимализмын тухай ойлголт, Соёлын өв, Богцон дахь өв соёл зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

### **2.1.11 Соёл, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд цахим хичээлийн сан бүрдүүлэх**

Соёл, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд “Биеэ авч явах соёл”, “Минимализмын тухай”, “Харизм”, “Монгол орноор аялахуй”, “Гоо сайхны тухай ойлголт”, “Дэлхийн өв бидний соёл зэрэг 11 цахим хичээлийг боловсруулж хэрэглэгдэхүүний тоог нэмэгдүүлээ.

### **2.1.12 Бие дааж боловсрол дээшлүүлэх үйлчилгээний хүрээнд танхимын ба зөөврийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ.**

2021 онд танхимаар байгууллагынхаа багш ажилчид, сурагчид, Арвист Хангай сургуулийн 6-12 ангийн сурагчид, дүүргийн иргэд, мэргэжлийн ангид суралцагч 378 иргэнд уран зохиолын ном болон сурах бичгийн нийт 532 ширхэг номоор үйлчлэв.

Мөн Хүүхдийн номын ордон, Д.Нацагдоржийн нэрэмжит номын сантай хамтран ажиллах гэрээ байгуулж 4 удаа зөөврийн 600 ширхэг уран зохиол, хүүхдийн уран зохиолын номоор үйлчилсэн.



Зураг. 9



Зураг. 10



Зураг. 11

### **2.1.13 Амьдрах ухааны боловсрол олгох сургалтын хүрээнд чанартай боловсролын үйлчилгээг иргэдэд хүргэнэ.**

Хан-Уул дүүргийн Албан бус Насан туршийн боловсролын төвийн Амьдрах ухааны боловсролын агуулгын хүрээнд иргэд болон албан байгууллагуудын албан хаагчдад сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан байна.


2021 оны жилийн эцсийн байдлаар Амьдрах ухааны агуулгын хүрээнд 86 удаагийн давтамжтай сургалтаар нийт 2387 иргэнд хүрч үйлчилсэн байна. Танхимын сургалтаас гадна цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор онлайн сургалтын платформ буюу google meet, zoom программ ашиглан дүүргийн дэргэдэх хэлтэс албадын ажилтан албан хаагчид, ЕБС-ийн багш ажилчид, ЕБС-н сурагчид, ШУТИС-ийн МСҮТ-ийн оюутан залуучуудад сургалтуудыг тус тус зохион байгуулж ажиллалаа.



Зураг. 12



Зураг. 13



Зураг. 14



Зураг. 15

#### **2.1.14 Дүйцсэн хөтөлбөрийн ангийн сурагчдад уншлагын цагийн хөтөлбөр боловсруулан батлуулж, сургалт зохион байгуулна.**

- Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн ангийн сурагчдад “Уншлагын цагийн хөтөлбөр” боловсруулж, 1-5 дугаар сард цахимаар, 9-12 дугаар сард танхимаар давхардсан тоогоор 364 сурагчийг хамрууллаа.
- Ном уншихын ач тус сэдвээр цахим постер бэлтгэн ангийн группт тавьсан.
- Хүүхдийн номын ордонтой хамтран хүүхдийн зохиолч Ж.Дашдондогийн 80 жилийн ойд зориулсан уран уншлагын уралдаанд 2, “Ээждээ хүргэх чин сэтгэлийн үгс 3” захидлын уралдаанд-2, “Уран дүрслэлийн хөгжилтэй аялал” уралдаанд-2 сурагчийг оролцуулж, зөвлөгөө өгч ажилласан.

#### **2.1.15 Дүүргийн бичиг үсэггүй иргэдийн сургалт**

Энэ хичээлийн жилд бичиг үсгийн анхан шатны сургалтад 24-42 насны 12 иргэн хамрагдсанаас 4 иргэн өмнөх түвшингөө ахиулж, 8 иргэн шинээр бичиг үсэгт тайлагдлаа. Иргэд 52 цагийн танхимын сургалтад хамрагдсан бөгөөд хөл хорио тогтоосон эхний үед сурагчид цахим орчинд ажиллаж чадахгүй, нэгж болон дата байхгүй гэдэг шалтгаанаар сургалт доголдож байсан боловч, хөл хорио суларсан үед багш нар байгууллага дээр интернетийн орчинд хэрхэн ажиллах 4 цагийн танхимын сургалт явуулж, цахим орчинд ажиллах чадвар олгож, уншиж бичүүлж сургалаа. Цахимаар 48 цагийн сургалтыг зохион байгуулсан.



График. 5


### 2.1.16 Бичиг үсгийн боловсролоос хоцорсон цэргийн насны залуучуудын судалгааг гаргаж, боловсролын түвшинг тогтоон, сургалтыг зохион байгуулах

Хан-Уул дүүргийн 2020 оны цэрэг татлагын 2 дугаар ээлжийн үеэр бичиг үсгийн боловсролгүй 6 цэргийн насны иргэдийн судалгааг гарган, 4 залууст бичиг үсгийн дунд шатны сургалтыг зохион байгуулж ажилласан.

### 2.1.17 Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх

Хөл хорионы улмаас байгууллагын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн тул сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг цахим хэлбэрээр зохион байгууллаа. Цахим зөвлөгөөний зар мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэсэн.

Үйлчилгээнд 2021.01 сард-4 иргэн, 2 сард-3 иргэн, 3 сард 4 иргэн нийт 11 иргэнд 10 цагийн ганцаарчилсан зөвлөгөө өглөө.



Зураг. 16



Зураг. 17

Мөн 9-12 сард байгууллагын сурагчдад давхардсан тоогоор 73 нийт 83 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Мөн иргэдэд сэтгэл зүйн боловсрол олгох зөвлөмж боловсруулан зурагт хуудас хэлбэрээр байгууллагын цахим хуудас, дүүргийн сайтаар дамжуулан иргэдэд хүргэв.





Зураг. 18



Зураг. 19

### 2.1.18 Иргэдэд сэтгэл зүйн боловсрол олгох сургалт зохион байгуулах

Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 60 дугаар сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдын 118 эцэг эхчүүдэд 2021.02.15-2021.02.17 хүртэл 3 хоногийн хугацаанд хүмүүжлийн эерэг арга багц сургалтыг “Хүүхдийн нас болон хөгжлийн онцлог”, “Хүүхдийн хувийн онцлог” сэдвээр нийт 6 цагийн сургалтыг зохион байгуулан явууллаа.

Сургалтаар хүүхдийн нас насанд гарах өөрчлөлт, хөгжил болон хөгжлийг хэрхэн дэмжих мөн хүүхдийн ялгаатай байдал гэж юу болох, ялгаатай байдлыг бий болгодог хүчин зүйлс цаашлаад хүмүүжлийн явцад юуг анхаарах талаар мэдээлэл өглөө. Мөн эцэг эхчүүд хүүхдийнхээ дотоод ертөнцийг таних, давуу болон анхаарал хандуулах асуудлыг ялгахад туслах дасгалуудыг ажиллалаа.



Зураг. 20



Зураг. 21

Мэргэжлийн анхан шатны сургалтад 9-12 сард хамрагдсан 120 иргэн, байгууллагын багш ажилчид, ШУТИС-ийн харьяа МСҮТ-ийн 75 багш нийт 485 иргэнд сургалт зохион байгуулав.

### 2.1.19 Сургууль завсардсан хүүхдэд зориулсан танхимын сургалт

Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн танхимын сургалтаар сургууль завсардсан бага ангийн 8-15 насны 11 сурагч, дунд ангийн 14-19 насны 11 сурагч нийт 22 сурагч суралцаж байна.

### 2.1.20 Тусгай хэрэгцээт иргэдийн шаардлагад нийцсэн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх

- Жайка Олон Улсын байгууллагаас зарласан 2021 оны 11 дүгээр сараас 2022 оны 5 дугаар сарыг дуустал хэрэгжих “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурлагын хоцрогдол

арилгах сургалт” төсөлд шалгарч, хэвтрийн болон хүнд хэлбэрийн 6 хүүхдэд явуулын үйлчилгээ үзүүлэхээр 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж эхэллээ.

- Дүүргийн Засаг даргын 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/160 захирамжаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэхдээ Тусгай хэрэгцээт боловсролын багш ажиллуулахаар батлуулсаны дагуу 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс багш авч ажиллууллаа.

- Монгол Улсын Их Хурлын 2017 оны 46 дугаар тогтоолын 4-т “хэвтрийн болон, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг Насан туршийн боловсролын төв хариуцна” гэж заасны дагуу манай байгууллагын эхний хагас жилийн нэг гол ажил нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэлгэрэнгүй судалгааны баазтай болохыг зорьж, Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дээр амьдардаг, 21 хороонд бүртгэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй 1-18 насны 601 хүүхдийн судалгаанд анализ хийлээ. Үүнд:

*Хүснэгт 1. Хан- Уул дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтын судалгаа*





График. 6

*Хүснэгт 2. Сургуулийн гадна байгаа хүүхдийн судалгааг бүсчлэн авч үзвэл*



График. 7

- ХУД-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан мэргэжлийн зөвлөгөө, тусламж үзүүлэх зорилготой фэйсбүүк хаалттай групп нээсэн бөгөөд тус группд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээ мэдээлэл оруулан ажиллаж байна.



Зураг. 22

С. Энгийн иргэдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхэд өгөх зөвлөгөө гарын авлага хийсэн.



Зураг. 23



Зураг. 24

Ковид-19 цар тахлын үед цахимаар хөгжлийн бэрхшээлтэй 2 сурагчтай хамтран ажилласан бөгөөд эхний ээлжинд эцэг эхээс асуумж бөглүүлэн ярилцлагын аргаар судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс үзэхэд хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ахуйн засал, хөдөлгөөн засал ихээхэн хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон эцэг эхтэй цахим хэлбэрээр ажиллах, харилцах амаргүй байсан ба техник, технологийн мэдлэг дутмаг, багш хүүхэд шууд харилцахад хүүхэд багшийг анзаарахгүй байх, хичээлд төвлөрөхгүй байх, эцэг эх багш алсын зайнаас хамтран хүүхэд сургалт орно гэдэг амаргүй байсан. Гэвч боломжгүй гэдэг үгээр хаацаллалгүй эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран ажиллах, хүүхдийн бэрхшээлийн төрлийг тодорхойлох, ялгаатай чадвар, онцлогт тохирсон хичээлийн хөтөлбөр, заах арга зүйгээр сургалт үйл ажиллагааг зохион байгуулах нь нөгөө талаараа маш их давуу тал гэж харж байна.

**2.1.21 Насанд хүрэгчдэд зориулсан зайны сургалт**

## Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтын мэдээлэл

2021-2022 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр 95 суралцагч Боловсролын салбарын мэдээллийн санд баталгаажин, бага ангид 10, дунд ангид 20, ахлах ангид суралцагч суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 5-р ангийг 2 суралцагч, 9-р ангийг 6 суралцагч, 12-р ангийг 35 суралцагч төгсөж боловсрол эзэмшлээ.

### 2.1.22 Лам хүүхдэд зориулсан танхимын болон зайны сургалт

Хан–Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрладаг Наро Банчин институтийн дэргэдэх Амирлахуй хийдийн 7–11 насны 4, 15 настай 2 нийт 6 лам хүүхдийг дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулан сургалтыг танхимаар явуулж, тухайн ангийн судлагдахууны агуулгыг бүрэн эзэмшүүлж суралцагчдын мэдээллийг боловсролын мэдээллийн нэгдсэн системд оруулж, анги дэвшүүлэн баталгаажууллаа.

## 2.2. Олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа

### 2.2.1 Санхүүгийн боловсролын агуулгын хүрээнд олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах

• “Дэлхийн Мөнгөний Долоо хоног 2021” нөлөөллийн ажлын хүрээнд “Суралц, Хуримтлуул, Өсгө” уриан дор 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрөөс 4 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд хүүхэд залуучууд, насанд хүрэгчдэд санхүүгийн боловсрол, мэдлэг мэдээлэл олгох, олон нийтэд таниулах ажлыг Хаан банкттай хамтран зохион байгуулж нийт 297 иргэнд хүрч ажиллалаа. Энэ ажлын үр дүнд “Хуримтлалтай хамт олон” үйл ажиллагааг зохион байгуулж нийт ажилчдын 46.1% нь цалингаасаа хуримтлал үүсгэлээ.



Зураг. 25



Зураг. 26


• Дэлхийн хуримтлалын өдрийн хүрээнд “Бүгдээрээ хуримтлуулъя” уриан дор санхүүгийн боловсрол олгох 1 сарын аяныг зохион байгуулж 287 ирнэгийг хамруулсан.

**Цахим постер оруулах**-Санхүүгийн Хуримтлал ба хадгаламж, Санхүүгийн ухаалаг хэмнэлт, Өрхийн төсвийн үндсэн ойлголт, Зээл гэх зэрэг сэдвийн хүрээнд мэдээлэл өгөх зорилготой постерыг хийж дүүргийн иргэдэд цахимаар мэдээлэл хүргэж ажиллалаа.


### 2.2.2 Гэр бүл, эрүүл мэндийн боловсролын агуулгын хүрээнд цахим хэлбэрээр олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах

“Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Гэр бүлийн үнэ цэн” цахим нөлөөллийн үйл ажиллагааг 2021 оны 4 дүгээр сарын 26-наас 5 дугаар сарын 14 хүртэл зохион байгуулж, нийт 135 иргэн оролцлоо. Энэ ажлын хүрээнд “Бид гэр бүлээрээ” видео контент, захидал болон шүлэг бичих уралдаан, гэр бүлдээ хайр түгээх, гэр бүлийн үнэ цэний талаарх зурган мэдээллүүдийг иргэдэд түгээн ажиллалаа.





Зураг. 27



Зураг. 28

### 2.2.3 Эрүүл мэндийн боловсролын агуулгын хүрээнд олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах


2021 онд Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийн хүрээнд ШУТИС-ийн МСҮТ-ийн 2 дугаар дамжааны 185 оюутны дунд “Бие биеэ дэмжье” нөлөөллийн ажлыг зохион байгуулж, өртөөчилсөн сургалт хийж, эсээ бичлэгийн уралдаан явууллаа. Энэ ажлын гол зорилго нь залуу үед БЗДХӨ, ХДХВ-ийн талаар ойлголт өгөх явдал байв.

### 2.2.4 Иргэний эрх зүйн боловсролын агуулгын хүрээнд иргэд олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулна.


Жендэрт сүүрилсэн хүчирхийлэлтэй тэмцэх аяны хүрээнд “Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай” уриан дор олон нийт рүү чиглэсэн нөлөөллийн ажлыг 126 иргэнд зохион байгуулж ажилласан юм. Үүнд аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд иргэд олон нийтийн ойлголт хандлага мэдлэгийг дээшлүүлж жендэрт сүүрилсэн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд иргэн бүрийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” зэргийг иргэдэд танилцуулах нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллалаа.




Зураг. 29



Зураг. 30



Зураг. 31



Зураг. 32

## 2.2.5 Харилцаа, ёс зүйн боловсролын олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа

"Цахим орчин-Эерэг нөлөө" аян – 2021 оны 1 дүгээр сарын олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд өөрийн цахим орчноороо дамжуулан бусдад эерэгээр нөлөөлөгч иргэдийг олж, тэдний зөв үлгэр дуурайлыг бусадтай хуваалцах, бие биенээсээ суралцах, цахим орчинд гэгээлэг зүйлсийг түгээх зорилгоор энэ цахим аяныг зохион байгуулсан. Нийт 128 иргэн оролцож, 18204 иргэн цахим хандалт хийж бидний ажлыг дэмжин оролцлоо.



Зураг. 33

## 2.2.6 Соёл, гоо зүйн боловсрол олгох сургалтын агуулгын хүрээнд иргэд олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулна.

"Богцон дахь өв соёл" олон нийтийн үйл ажиллагаа:

Албан бус-Насан туршийн боловсролын төвийн боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр суралцагч сурагчдын "Өвийн жим" клуб 9 гишүүнтэйгээр байгуулсан.

"Өвийн жим" клубын сурагчдад "Богцон дахь өв соёл" өвийн боловсролын сургалтыг 18 сурагчид зохион байгуулсан.

Хангай МСҮТ-ийн Аялал жуулчлалын нэгдүгээр ангийн 20 суралцагчдад "Богцон дахь өв соёл" сургалтыг зохион байгуулж "Эко дүүргийн өв соёлоороо бахархъя" сэдэвт уулзалтыг 25 суралцагчтай зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орших хөшөө дурсгалын судалгаа гарган, танилцуулга бэлтгэх ажлыг клубын 9 сурагчидтай хамтран хийж гүйцэтгэсэн.

"Өвийн жим" клубын сурагчдын дүүргийн нутаг дэвсгэрт орших хөшөө дурсгалын танилцуулгаар хийсэн "Том ном" бүтээлийг 20 сурагчдад танилцуулга зохион байгуулсан. Дээрх үйл ажиллагаанд нийт 101 хүн хамрагдсан.

## 2.2.7 Бие дааж боловсрол дээшлүүлэх үйлчилгээний сургалтын агуулгын хүрээнд иргэд олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулна.

Монгол Улсад Орчин цагийн номын сан үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан [Соёлын яам](#), [Нийслэлийн Соёл, урлагийн газар](#), [Монгол Улсын Үндэсний номын сан /National Library of Mongolia/-](#) гийн дэмжлэгээр манай номын сангаас "Номын жим" аялалын хөтөлбөрийг эхлүүллээ.

Энэхүү хөтөлбөрийн 14 дэх удаагийн аялал 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр болж, Хан-Уул дүүргийн НТБ-ын төвийн Дуламсүрэн багштай боловсрол нөхөн олгох ангийн 10-16 насны сурагчид, Д.Нацагдоржийн нэрэмжит номын сангийн идэвхтэн сурагчид нийт 120

хүүхдүүдийг хамарсан 1 сарын аянг өрнүүлэв. Энэхүү аяны гол зорилго нь сурагчдыг номтой нөхөрлүүлэх, монгол өв уламжлалтай танилцах, монгол ахуйд ойртуулах юм.



Зураг. 34



Зураг. 35

### 2.3. Цар тахлын үеийн бэлэн байдал

2.3.1. Ковид – 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.

Улсын Онцгой комисс, Дүүргийн Онцгой комисс, Мэргэжлийн хяналтын газраас гаргасан заавар, зөвлөмжийн дагуу:

- Байгууллагын коридор, анги танхим, өрөө тасалгаанд Ковид – 19 -өөс урьдчилан сэргийлэх, гар угаах, зай барих, амны хаалт зүүх зэрэг зурагт хуудас байрлуулах
- Ангиудад кварцын гэрэл тавьж халдваргүйтгэл хийх
- Эцэг эх, сурагчид, иргэдэд зориулсан постер хийх
- Тусгаарлах өрөө гаргах
- Нэг удаагийн хувцас хэрэглэл авах
- Ариутгалын бодисын нөөцтэй байх
- Халуун хэмжигч, гар ариутгагч авах зэрэг ажлуудыг хийж хийт 676,600 төгрөг зарцууллаа.

Мөн эрсдэлийн үед хэрхэн ажиллах төлөвлөгөө гарган хэлэлцүүлж, батлуулан мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын ажилчдыг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөлийг бүрдүүлж, цахим орчинд хэрхэн ажиллах 10 удаагийн сургалтыг зохион байгууллаа.



Зураг. 36



Зураг. 37

Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын А/292, А/525 тушаал, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, хичээл эхлүүлэх бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллав.

Бүх багш ажилтан, сурагчид 32 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Байгууллагын ундны усыг мэргэжлийн лабораторид шинжилгээнд өгч дүгнэлт гаргуулан, мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэлийг сар бүр хийлгэж байна. Захирлын 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А/22 тоот тушаалаар сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш нарын бүрэлдэхүүнтэй “Хөл хорионы үед ажиллах баг, журам”-ыг томилж, хяналт тавин ажиллуулсан.

Байгууллага дээр 2 цаг тутамд халдваргүйтгэл хийх ариутгалын 2 бууг 140.000 төгрөгөөр авч ариутгалыг хийж хэвшлээ. Боловсрол нөхөн олгох ангийн сурагчдын хичээлийг танхим болон цахимаар явуулж байна.

Мөн гар ариутгагч, ариутгалын спирт, маск, нүүрний хаалт, 1 удаагийн хувцас зэрэгт 780,000 төг нийт 920.000 төгрөг зарцууллаа.

## **2.4. Хотын соёл**

### **2.4.1 Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Хотын соёл” олон нийтийн аян өрнүүлнэ.**

- Байгууллагын цахим хуудас болон хотын соёл пэйж хуудсанд “Биеэ авч явах соёл” хичээлийг бэлтгэн байршуулж 2038 иргэдээс хандалт авлаа. Мөн ерөнхий боловсролын 32, 34, 52, 18 дугаар сургуулийн дунд ангийн сурагчдад дээрх сургалтыг зохион байгуулж, 251 сурагч хамрагдлаа.
- “Хотын соёл” аяны хүрээнд иргэдийг олон нийтийн газраар явахдаа соёлч, зөв боловсон биеэ авч явахад уриалсан уриалга бүхий 10 постер бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулав.
- “Дохионы хэлийг соёл болцгооё” цуврал 5 хичээлийг байгууллагын цахим хуудсаар түгээсэн.
- Нийслэлийн Урлаг Соёлын газраас зохион байгуулж буй үйл ажиллагаа, мэдээлэл, постер, шууд бичлэгийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан дүүргийн иргэдэд түгээлээ.
- Дүйцсэн хөтөлбөрийн бага, суурь, ахлах бүлгийн 107 сурагчдад цахимаар “Хотын соёл” хичээлийн хөтөлбөрийг боловсруулан нийт 12 удаагийн сургалтыг зохион байгууллаа.

## **ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ–ИРГЭН БҮРТ**

### **3.1. Ухаалаг төрийн үйлчилгээ**

3.1.1 Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх тухай” А/452 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах:

Баримтад цахим хувь үйлдэх, бүх шатны байгууллагаас архивын мэдээлэл-лавлагааг онлайн хэлбэрээр авах, ашиглуулах нөхцөлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын:

А-тушаал 49 /хавсралт-113 хуудас/ нийт 165 хуудас, Б тушаал 35 /хавсралт-1 хуудас/ нийт 35 хуудас, бүгд 83 тушаал /хавсралт-114 хуудас/ нийт 197 хуудас баримтыг Archive Edoc программд оруулан хянуулсан.

Archive edoc программд А тушаал бүртгэсэн байдал.



Хөмрөгийн код	Хөмрөгийн дугаар	Хөмрөгийн нэр	Дансны дугаар	Хадгаламжийн нэгжийн дугаар	Баримтын төрөл	Цаасан баримтын дугаар	Хуудасны тоо	Хуудасны дугаар эхэлсэн	Хуудасны дугаар дууссан	Байдал
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	01	02020	Тушаал	A/49	1	135	135	Хө...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	01	02020	Тушаал	A/48	1	134	134	Ме...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	01	02020	Тушаал	A/47	1	133	133	Тэт...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	01	02020	Тушаал	A/46	1	132	132	Хө...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	01	02020	Тушаал	A/45	1	131	131	Хө...

Зураг. 38

Archive edocs программд Б тушаал бүртгэсэн байдал.

Хөмрөгийн код	Хөмрөгийн дугаар	Хөмрөгийн нэр	Дансны дугаар	Хадгаламжийн нэгжийн дугаар	Баримтын төрөл	Цаасан баримтын дугаар	Хуудасны тоо	Хуудасны дугаар эхэлсэн	Хуудасны дугаар дууссан	Байдал
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	02	02020	Тушаал	Б/35	1	35	35	Ма...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	02	02020	Тушаал	Б/34	1	34	34	Сай...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	02	02020	Тушаал	Б/33	1	33	33	Ший...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	02	02020	Тушаал	Б/32	1	32	32	Чуу...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	02	02020	Тушаал	Б/31	1	31	31	Со...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	02	02020	Тушаал	Б/30	1	30	30	Пун...
609	0097	Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв	02	02020	Тушаал	Б/29	1	29	29	Дий...

Зураг. 39

**3.1.2 Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн төр захиргааны байгууллагын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилт, Албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн /Шинэчилсэн найруулга 2020.04.24/ хэрэгжилт:**

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архивын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар, Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам болон холбогдох эрх зүйн актуудыг дагаж мөрдөж ажиллаж байна. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу ирсэн бичиг 201, явсан бичиг 70-ийг бүртгэж шийдвэрлэн, хяналт тавих, албан хэрэг хөтлөлтийн шатанд хадгалан ашиглаж, хөтлөх нэрийн жагсаалтын дагуу албан хэрэг бүрдүүлэх, ERP системд албан бичиг боловсруулах зэрэг ажлыг хийж байна.

**3.1.3 Дүүргээс аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлж буй үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.**

2021 оны 1 дүгээр сараас Дүүргийн Засаг даргын дэргэдэх 35 хэлтэс албад, 21 хороо, төрийн өмчийн 18, төрийн бус 15 ерөнхий боловсролын сургууль, 29 цэцэрлэг, 5 их

дээд сургууль, 4 сургалт үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа Түр хамгаалах байр, 015 дугаар цэргийн анги, Монгол банк, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Хүүхдийн номын ордон, Наро банчин хийд, ШШГЕГ 401 дүгээр хорих ангийн нэгдсэн эмнэлэг, “Дэлхийн зөн” Хан–Уул ОНХХ, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, “World share” ОУБ, “Good neighbors” ОУБ, “Sunrise” ТББ, “Гэгээн Art therapy” байгууллага, Голомт банкны Хан – Уул дүүрэг дэх бизнес салбар, Хилийн чанад дахь Монголчуудын холбоо, ОБ пластик, МУБИС-ийн БоСС, АПУ ХК зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг үргэлжлүүлэн байгуулж, сургалтын захиалга авч, хуваарьт оруулж цахимаар сургалт болон нөлөөллийн ажил зохион байгууллаа.

Цахим сургалтаас гадна дараах байгууллагуудтай хамтран мансууруулах бодисын хор хөнөөлийг сурталчлах, боловсрол нөхөн эзэмшиж буй сурагчдын бүртгэл, лам сурагчдад боловсрол олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нэгдсэн судалгаатай болох зэрэг үр дүнд хүрсэн ажлуудыг хийсэн. Жишээ нь:

- Дүүргийн Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучуудын хэлтэстэй хамтран “Дэлхийн гэр бүлийн өдөр”-т зориулсан нөлөөллийн ажил
- Цагдаагийн 1,2-р хэлтэстэй хамтран эрүүлжүүлэгдсэн иргэдэд мансууруулах бодисын хор хөнөөлийг сурталчлах ажил
- Боловсролын хэлтэстэй хамтран боловсрол нөхөн эзэмшиж буй сурагчдын бүртгэл, баталгаажуулалт хийх
- Наро банчин хийдтэй хамтран лам сурагчдад боловсрол олгох
- Голомт банктэй хамтран “Дэлхийн мөнгөний 7 хоног” нөлөөллийн ажил
- ШШГЕГ 401 дүгээр хорих ангийн нэгдсэн эмнэлэгт англи хэлний онлайн сургалт
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран Хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 45 хүүхдийн судалгаа, болон сургуулийн гадна байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нэгдсэн судалгаатай болох зэрэг ажлуудыг зохион байгуулж, үр дүнд хүрч байна.

Мөн 12 дугаар сарын оёдол эсгүүр, үсчин, англи хэлний сургалтаа цахимаар бүртгэж, нийт 35 иргэнийг бүртгэлээ.

**3.1.4 Чиг үүргийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээллээ тухай бүр дүүргийн албан ёсны /www.khanuul.mn/ веб хуудаст байршуулж, иргэдийг үнэн зөв, шуурхай мэдээллээр ханган, цахим мэдээллийн сувгаар уялдаа холбоотой, нягт хамтран ажиллах.**

Манай төв нь 2021 оныг “Цахим платформыг хэрэгжүүлэх” жил болгон зарлаж, үндсэн 6 чиглэл, санхүүгийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, олон нийт рүү чиглэсэн нөлөөллийн ажил үйлчилгээг цахимаар нээлттэй хүртээмжтэй зохион байгуулж байна. Үүнд:

- Дүүргийн Khanuul.mn сайтад байгууллагын үйл ажиллагаа, явцын болон сарын мэдээг тогтмол гаргаж байршуулдаг.

Нүүр хуудас ТАНИЛДУУЛАГА УДИРДЛАГА МЭДЭЭЛЭЛ ЗДТ ХЭЛТЭС ИЛ ТУЦ БАЙДАЛ ШИЛЭН ДАНС

Нүүр хуудас > Мэдээлэл > ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ НЬ 3 ДУГААР САРД ЦАХИМ ОРЧНООР ДАМЖУУЛАН ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.

**Мэдээлэл**

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ НЬ 3 ДУГААР САРД ЦАХИМ ОРЧНООР ДАМЖУУЛАН ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.**

© 2021-04-01

Сургалтын хүрээнд:

- Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран эцэг эхчүүд, суралчдад зориулан
- Бага насны хүүхдийн стресс түүний шалтгаан сэдвэг лийв хичээлийг бэлтгэн хүргэлээ.Байгууллагын цахим хуудсаар дамжуулан
- Харилцаа, өс зүйн боловсролын агуулгын хүрээнд "Эерэг харилцаа" цахим хичээлийг бэлтгэн байршуулж иргэдэд хүргэв.



Зураг. 40

• BEST FM 98.6-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, байгууллагын үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийн боловсрол, хувцаслалт, санхүүгийн боловсрол, элсэлтийн ерөнхий шалгалт, мэргэжил сонголт зэрэг сэдвээр нийт 4 удаагийн ярилцлагад зочноор уригдан оролцож байгууллагаа сурталчиллаа.



Зураг.42

Нүүр хуудас > Мэдээлэл > ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН МЭДЭЭЛЭЛ

**Мэдээлэл**

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АЛБАН БУС НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН МЭДЭЭЛЭЛ**

© 2021-01-25

Хан-Уул дүүргийн Насан туршийн боловсролын төв 2021 оны ажлын төлөвлөгөөгөө баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Багц ажилдаа цахим орчинд ажиллах нөхцөлөөр ханган байгууллагынхаа интернет сүлжээний тоног төхөөрөмжийг шинэчиллээ.

Хан-Уул дүүргийн албан байгууллага, хороодтой хамтран ажиллах гэрээг цахимаар илгээн сургалтын захиалгыг авч эхний байгууллагуудаа цахим сургалтыг явууллаа. Үүнд Хан-Уул дүүргийн онцгой байдлын хэлтэс, Гал унтраах яврах 14, 30, 65-р ангийн ажилтнуудад багш С.Анхтуяа, А.Болормаа нар цагийн менежмент, ажлын байран дахь бэлтгэлийн дарамт сэдвээр тус тус сургалт өглөө.

Мөн байгууллагын сургалтын албаны төлөөлөгчид тусгасны дагуу багш нар байгууллагын ажилчид болон дүйцсэн хөтөлбөрийн ангийн суралцагчдаа цахим сургалтыг 7 хоног бүр явуулж эхлээд байна.

Ковидын нөхцөл байдалтайгаар цахим постеруудыг Хан-Уул дүүргийн леж нийтэлж, 1-р сард "Цахим орчин-Эерэг нөлөө" аяныг өргүүлж иргэдэд хандсан нөлөөллийн ажлыг хийлээ. FM-98.5 радиод байгууллагынхаа сургалт үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч сар бүр үргэлжлүүлэн хийгээр боллоо.



Зураг. 41



Зураг. 43

• Насан туршийн боловсролын Үндэсний төв, Монгол телевизтэй хамтран Тогтвортой хөгжлийн боловсролын хүрээнд ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн чадавхыг сайжруулах, өрхийн орлогыг дэмжих чиглэлээр оёдол эсгүүр, компьютер, үсчний сургалтаар видео контент хийж, түгээн дэлгэрүүлсэн.




Зураг. 44




Зураг. 45

• [www.hudabntbt.edu.mn](http://www.hudabntbt.edu.mn), Насан туршийн боловсролын үндэсний төвийн [www.nclm.mn](http://www.nclm.mn) вэб сайтуудад үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж байна.



Зураг. 46



Зураг. 47

## 3.2. Мэргэшсэн тогтвортой төрийн алба

### 3.2.1 Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах, хэлтэс, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулна.

Манай төв нь сургалтын алба, захиргаа аж ахуй гэсэн 2 бүтэцтэй бөгөөд 14 хоног тутам байгууллагын шуурхай зөвлөгөөн хийж ажлаа дүгнэж хэвшсэн. Мөн залуу багш нарыг чадавхжуулах зорилгоор сар бүрийн 1 ба 3 дугаар долоо хоногийн Баасан гарагт арга зүйн цаг зохион байгуулдаг. Байгууллагын зүгээс багшийг хөгжүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хөтөлбөр төлөвлөгөөтэй.

#### 1. Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор:

А. Дээд газраас зохион байгуулсан 93 цагийн сургалт

Багш нарын заах арга зүйг сайжруулах 25 цагийн сургалт

Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр байгууллага дээр зохион байгуулсан 12 цагийн сургалт

Багш нар өөрийгөө хөгжүүлэх бие даасан 166 цагийн сургалт

БМДИ – ээс зохион байгуулж буй эхний жилдээ ажиллаж буй багш нарын / 4 багш/ 240 цагийн сургалт нийт **533** цагийн сургалтад багш нараа хамруулаад байна.

А. МУБИС – д “Боловсрол судлал”-ын чиглэлээр багш С.Энхзаяа магистрт суралцаж байгаа бөгөөд сургалтын төлбөрт 500.000 төгрөгний дэмжлэг үзүүллээ.

В. Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр “Дохионы хэл” - ний цуврал хичээлийг долоо хоног бүр зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах боломжийг хангаж байна.

С. Мэдээллийн технологийн чиглэлээр Онлайн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй /google meet, zoom, microsoft teams/, Үүлэн технологи /google docs, google sheets, google slides, google forms/, We transfer, Team viewer, Hand brake, ABBYY программууд болон цахим хичээл боловсруулах арга зүйд суралцаж байна.

Д. Байгууллагын багш, ажилтнуудын ажлыг сар бүрийн 20 – нд дүгнэж хэвшсэн.

#### 2. Цалин хөлс, шагнал, урамшууллын олгох ажлын хүрээнд

- Улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал 1 дүгээр улиралд-5,468,400 төг
- Монгол Улсын Засгийн газрын 2018.12.19-ний 382 тоот тогтоолыг үндэслэн санаачилгатай ажилласан багш, ажилчдад ур чадварын нэмэгдэлд -3,381,600 төг



- Мэргэжлийн зэргийн нэмэгдэл - 2,713,420 төг
- Багш ажилчдад унааны мөнгө -856,000 төг
- Төрд ажилласны нэмэгдэлд - 8,688,983 төгрөгийг ажлыг үзүүлэлтийг харгалзан олгосон.

### **Албадын ажлын уялдаа холбоог сайжруулах ажлыг зохион байгуулсан байдал**

- Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хэлтсээс хамтран ажиллах хүсэлт тавьсны дагуу “Архигүй, хүчирхийлэлгүй–Аз жаргалтай монгол гэр бүл” төсөл бичиж Нийслэлийн ГБХЗХ-т хүргүүлэн, төсөл маань дэмжигдэн 5 сая төгрөгний санхүүжилтийг авч, 9-12 сарын хооронд хэрэгжүүлж ажиллалаа.
- GOOD NEIGHBORS олон улсын байгууллагатай хамтран зорилт 4, 5, 6, 7, 8-р хорооны ЕБС-ийн сурагчид тэдний эцэг эхэд сургалт болон нөлөөллийн ажил зохион байгуулах гэрээ хийж, нийт 120 хүүхдийг хамруулав.
- “Нэг хаалга-Нэг шинжилгээ” аяныг зохион байгуулж өрх бүрээс нэг иргэнийг шинжилгээнд хамруулсан. Тус аяны хүрээнд Хан-Уул дүүргийн 6 дугаар хорооны явуулын шинжилгээний багтай харилцаа холбоо тогтоон ажиллаж нийт 250 иргэний бүртгэлийг хийсэн.
- “Ритм фарм” эмийн сангийн эм зүйч Ч.Отгондуламтай харилцаа холбоо тогтоож албан хаагчдаа витаминжуулах үүднээс бүтээгдэхүүнүүдийг 25 хувийн хөнгөлөлттэй үнээр авч, Siberian wellness сүлжээ байгууллагаас Новомин-1 ширхэгийг 10 хувийн хөнгөлөлттэй үнээр авч нийт 102.000 төгрөгний үнэ бүхий дархлаа дэмжих бүтээгдэхүүнээр байгууллагын албан хаагчдын дархлааг дэмжив.

### **3.2.2 Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангана.**

Байгууллагын авлигын эсрэг ажлын төлөвлөгөө боловсруулан, Авлигатай тэмцэх газартай хамтран дүүргийн Боловсролын хэлтэс, төрийн ба төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн 234 удирдах ажилтан, багш нарт “Авлигын тухай”, “Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь” сэдвээр онлайн сургалтыг 2021 оны 4 сарын 16-нд зохион байгууллаа.


### **3.2.3 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.**

Сар бүрийн 20-ны өдөр нийт багш, ажилтнуудын ажлыг албан тушаалын тодорхойлолтыг үндэслэн сахилга хариуцлага, ёс зүйн алдаа гаргасан эсэхийг нэг үзүүлэлт болгон оруулдаг бөгөөд одоогоор ёс зүйн зөрчил гаргасан багш, ажилтан байхгүй байна.

Ажлын хариуцлага алдсан тохиолдолд ямар арга хэмжээ авахыг дотоод журамд оруулав.

### **3.2.4 Монгол Улсын Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах**

- Байгууллага дээр 3 хүний бүрэлдэхүүнтэй Ёс зүйн зөвлөлийг захирлын тушаалаар томилон 2021 онд ажиллах төлөвлөгөө гарган, багшийн ёс зүйтэй холбоотой соён гэгээрүүлэх 2 удаагийн сургалт зохион байгуулсан.
- Төрийн албан хаагчийн ёс зүй сэдвээр үйлчилгээний ажилчдад сургалт зохион байгуулав.
- Ажлын байрны бэлгийн дарамтын тухай мэдээллийг албан хаагчдад хүргэж, байгууллагын дотоод журамд нэмэлтээр оруулав.
- Багшийн ёс зүйн дүрмээр мэдээллийг самбар гарган, журмыг нийт багш,ажилтнуудад сурталчилж байна



Зураг. 48

- Байгууллагын бүх багш, ажилтнууд 2021 оны 1 дүгээр сарын 4-нд захиралтай “Ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах гэрээ” байгуулан ажиллаж байна.
- Багш нарыг соён гэгээрүүлэх зорилгоор байгууллагын ёс зүйн зөвлөлөөс 1 удаа сургалт зохион байгуулж, 1 удаа кейс үүсгэн ярилцлага зохион байгуулж бүх ажилтнуудыг хамруулав.

**ДӨРӨВ.НИЙГМИЙН ХӨГЖИЛ – ӨРХ БҮРТ**

**4.3 Хөдөлмөр эрхлэлт**

**4.3.1 Оёдол эсгүүрийн мэргэжлийн сургалт**

- 2021 онд 4,5, 9,10,11,12 саруудад танхимын сургалтыг 6 удаа зохион байгуулж, 62 иргэнийг хамрууллаа.
- “Гарын төөний арга”, “ Гарын төөний аргаар хүүхдийн баривч хийх нь” 2 цахим хичээлийг боловсруулж, цахимаар 6 удаа 36 нийт 98 иргэнийг хамруулан сертификат олгов.



Зураг. 49



Зураг. 50

**4.3.2 Үсчин, гоо сайхны мэргэжлийн сургалт**

- 2021 оны 4,5,9,10,11,12 сард танхимын сургалтыг 6 удаа зохион байгуулж, 60 иргэнийг,
- Мөн “Үсний будгийн тухай”, “Гэрийн нөхцөлд үсээ будах нь” цахим хичээл 2-ыг бэлтгэн, 4 удаа 28 иргэн, боловсрол нөхөн олгох ангийн 4 сурагч, нийт 92 иргэнийг хамруулж, үсчний 3 зэргийн үнэмлэх олголоо.



Зураг. 51



Зураг. 52

#### 4.3.3 Компьютерын насанд хүрэгчдийн анхан, дунд шатны сургалт зохион байгуулах

- 2021 онд компьютерын сургалтад танхим болон цахимаар нийт 937 иргэнийг хамруулав.
  - а. Компьютерын чиглэлийн агуулгын хүрээнд 2021.01 сараас 2021.05.15 хүртэл нийт 4 удаагийн Google бүтээгдэхүүнийг цуврал цахим хичээл бэлдэж цахим хуудас байршуулсан. Уг агуулгын хүрээнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 439 иргэнд үйлчилсэн.



График. 8

- б. Онлайн хурал хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй сургалт – Байгууллагын албан хаагчид, дүүргийн 16, 19, 20, 21 хороонд, спортын хороо, статистикийн хэлтэс, жижиг дунд үйлдвэрлэл 164 суралцагчид сургалт зохион байгуулласан.
- с. Цахим орчны зохистой хэрэглээ сургалт – 52-р сургуулийн 7 а, б, в, г, д, е, ё гэсэн нийт 7 бүлгийн 236 суралцагчид сургалт зохион байгуулласан.

#### 4.3.4 Компьютерын ахмад настны анхан шатны сургалт зохион байгуулах

- Ахмад хороотой хамтран ахмад настануудад компьютерын анхан шатны сургалт зохион байгуулж, интернет орчинд ажиллах чадварыг нэмэгдүүлэн “Компьютер түүний хэрэглээ”, “Онлайн хурал хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй” сэдвээр 42 иргэнийг хамруулав.
- 2021 оны 9.10.11 дүгээр сард танхимын сургалтаар 35 ахмад настанг гар утасны хэрэглээ, е Mongolia апп-ийн талаар сургалт зохион байгуулсан.

#### 4.3.5 Компьютерын сургалтын агуулгын хүрээнд цахим хичээлийн сан бүрдүүлэх

- Хөл хорионоос шалтгаалан танхимын сургалтын үйл ажиллагаа зайн буюу цахим сургалтын хэлбэрт шилжин ажиллах хэрэгцээ шаардлагад тулгуурлан компьютерын анхан шатны ээлжит хичээл бүрийг цахим PowerPoint, excel, word ашиглан онолын мэдлэг ойлголт хүргэж суралцагчдад илүү ойлгомжтой байхын тулд google app- аас google docs, sheets, slides ашиглан хамтран ажиллах, мэдээлэл солилцох сургалт руу шилжин ажиллаж байна.
- Хэрэглээний программууд болох Slidego, Canva, infographic, prize, Fiverr, Powtoon ашиглан гарын авлага, танилцуулах 20 хэрэглэгдэхүүн бэлтгэсэн
- Сургалтад хамрагдсан иргэдээс 15 судалгааны материал бэлтгэн, хэрэгцээний болон сэтгэл ханамжийн судалгааг Google Forms ашиглан авч хэвшлээ.
- Цахим контент бүтээх OBS, Camtasia программ ашиглан 4 цахим хичээл бэлдлээ.


#### 4.3.6 Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн дүйцсэн хөтөлбөрийн ангийн сурагчдад компьютерын боловсрол нөхөн олгох сургалт зохион байгуулна.

- 2021 оны эхний хагас жилд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр боловсрол эзэмшиж буй дунд болон ахлах ангийн 96 сурагчдад дараах сэдвүүдээр 16 цагийн цахим хичээл бэлтгэн орлоо.
- 2021 оны 9 сараас эхлэн танхимаар хичээллэж буй 85 сурагчдад БШУЯ-ны сайдын А/88 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгууллаа.

#### 4.3.7 Дүүргийн иргэдэд солонгос хэлний анхан шатны ярих чадвар хөгжүүлэх сургалтыг зохион байгуулна.

Хөл хорионы үед танхимын сургалт зохион байгуулаагүй бөгөөд “Солонгос хэлний эгшиг үсэг” цахим хичээлийг бэлтгэн дүүрэг, хороо, байгууллагын сайтуудад байршууллаа.

Мөн цахимаар бүртгэл хийж, 1-4 сард дүүргийн 45 иргэнд цахимаар сургалт зохион байгуулсан.



Зураг. 53



Зураг. 54

2021 оны 9 дүгээр сард 10 хүнтэй танхимын сургалтыг зохион байгуулсан бөгөөд Дүүргийн Засаг даргын захирамжаар 12 сарын 31 хүртэл 7 дугаар хороон дээр ажиллаж байгаа тул сургалт зохион байгуулсангүй.

#### Цар тахлаас үүдэн үнэлэх боломжгүй

#### 4.4. Дүүргийн төсөв, санхүү

4.4.1 Төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг иргэд олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг өндөржүүлнэ:




2021 оны төсвийн хуваарийн дагуу, эдийн засгийн ангилал бүрээр хийж гүйцэтгэн, шилэн дансанд оруулж, зарцуулалтыг ил тод нээлттэй самбарт байршуулан ажиллаж байна.


#### 4.4.2 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өмч ашиглалтыг сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулах:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, эд хариуцагч нарын хариуцаж буй эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмжийг сайжруулж, ашиглаж буй байдал хяналт тавьж, тооллогыг хагас жил, жилийн эцэст хугацаанд нь үнэн зөв чанартай сайн гүйцэтгэсэн.

Байгууллагын захирлын А тушаалаар хагас жил, бүтэн жилээр тооллогын комисс байгуулан ажиллаж байна.



Зураг. 55



Зураг. 56

#### 4.4.3 Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, авлага өр, төлбөр үүсгэхгүй байх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж харилцагч байгууллага болон ажилчдад өр, авлагагүй ажиллаж, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж сар бүрийн 1, 2 -нд тайлагнаж ажиллаж байна.

#### 4.4.4 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.


2021 оны төсөвт эд хогшил, урсгал засварын зардалд төсөв батлагдаагүй болно.

#### 4.4.5 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах:

2021 оны 01 дүгээр сараас 2021 оны 11 дүгээр сар хүртэлх : Бүтэн жилээр оруулах мэдээлэл, хагас жилээр оруулах мэдээлэл, улирал бүр оруулах мэдээлэл, сар бүр оруулах мэдээлэл, тухай бүрт оруулах мэдээлэл, болон 1. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 2. Байгууллагын батлагдсан орон тоонд

орсон өөрчлөлт **3.** Дараа жилийн төсвийн төсөл **4.** Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, **5.** Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг **6.** Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, гэх мэдээллүүдийг цаг хугацаанд нь үнэн зөв оруулж ажиллалаа.

Байгууллагын санхүүгийн самбар дээр шилэн дансны мэдээллийн байршуулан ажиллаж байна.



Зураг. 57

## ТАВ. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

### 5.1. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр

#### 5.1.1 Үндэсний бичгийн хичээлийг танхимын сургалтаар заах

А. Байгууллагын 17 багш, ажилтанд монгол бичгийн анхан, дунд, ахьсан шатны сургалтыг 3,9,10,11,12 дугаар сард зохион байгуулсан.

В. Дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол эзэмшиж буй 85 сурагчдад монгол бичгийн хичээлийг танхим болон цахимаар зааж байна.

#### 5.1.2 Төрийн албан хаагчдад чиглэсэн үндэсний бичгийн анхан, дунд шатны цахим сургалт зохион байгуулах

- 2021 оны 1, 2-р сард монгол бичгийн анхан шатны 24 цагийн сургалтыг дүүргийн Засаг даргын дэргэдэх 35 хэлтэс, албадын 326 иргэнд зохион байгуулж, 150 иргэнд сертификат олголоо.



Зураг. 58



Зураг. 59

• Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ахлах офицерүүдийн дунд монгол бичгийн сургалтыг явуулж, анги, хэлтсийн 34 ажилтан нийт 360 иргэнийг хамруулсан.

### 5.1.3 Үндэсний бичгийн сургалтад хамрагдсан иргэд, албан хаагчдын дунд тэмцээн зохион байгуулах

Байгууллагын багш ажилтан, сурагчдын дунд монгол бичгийн сайхан бичиг, уншлагын уралдаан зохион байгуулж, 41 хүнийг хамруулан, түрүүлсэн 3 багш нарыг шагнаж урамшуулав.

### 5.1.4 Үндэсний бичгийн сургалтын хувилбарт хэрэглэгдэхүүн боловсруулж, багшийн арга зүйг сайжруулах

Үндэсний бичгийн сургалтын хувилбарт хэрэглэгдэхүүн 321 ширхэгийг боловсруулж, багшийн арга зүйг сайжруулахын тулд заах арга зүйн 2 өдрийн сургалтад хамруулсан.

### 5.1.5 Сургалтад хамрагдсан иргэдийг хэрэгцээ, сэтгэл ханамжийн судалгаанд хамруулж, түвшин тогтоох шалгалт авч дүгнэлт хийх

Сургалтад хамрагдах хүсэлт ирүүлсэн 124 иргэн хэрэгцээний судалгаанд хамрагдсан бөгөөд үсэгнээсээ эхэлж сурах –60, бичиж сурах –40, уншлагын хурдаа нэмэгдүүлэх –21 иргэн байлаа.




График. 9

Сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан 157 иргэний судалгаанд анализ хийж үзвэл:

-Сургалт үр дүнтэй байсан-114

-Сургалт хэт хурдан байсан-31

-Миний түвшин ахьсан–142

-Дунд шатны сургалтад суух хүсэлтэй–111 гэж дүгнэснээс харвал сургалт үр дүнтэй




График. 10

## 5.2. Англи хэлний үндэсний хөтөлбөр

### 5.2.1 Иргэдийн англи хэлний анхан болон дунд шатны мэдлэг дээшлүүлэх сургалт зохион байгуулах

2021 оны 9 дүгээр сараас Онцгой байдлын хэлтэс, иргэдийн дунд нийт 45 ажилтанд танхимаар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа хорих 401 дүгээр ангийн нэгдсэн эмнэлгийн 120 албан хаагчдад цахимаар, бие даах даалгавар өгч, хамтран ажилласан. Нийт 165 иргэнийг хамруулав.

### 5.2.2 Байгууллагуудын албан хаагчдад чиглэсэн анхан, дунд шатны захиалгат сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулах

2021 оны 2 болон 3 дугаар сард Хан – Уул дүүргийн дэргэдэх нийт 7 хэлтсийн 114 албан хаагчид 16 цагийн сургалт зохион байгуулж, англи хэлний анхан шатны мэдлэг олгосон. 1 Өөрийн байгууллагын албан хаагчдаас хэрэгцээний судалгаа авч, 9 багшид 14 цагийн англи хэлний анхан шатны сургалт зохион байгуулсан. Нийт үйлчилсэн иргэдийн тоо -271

### 5.2.3 Англи хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж, сургалтад ашиглах

Цахим болон танхимын сургалтад зориулсан анхан, дунд, ахьсан шатны нийт 453 ширхэг хэрэглэгдэхүүн, 10 цагийн PPT бэлтгэж сургалтад ашиглаж байна.

### 5.2.4 Хан-Уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн дүйцсэн хөтөлбөрийн ангийн сурагчдад англи хэлний боловсрол нөхөн олгох сургалт зохион байгуулах

2021 онд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр боловсрол эзэмшиж буй 125 сурагчдад:

- Сургалт хөтөлбөрийн дагуу хичээл зохион байгуулах
- Бие даах даалгавар илгээх
- Явцын үнэлгээ хийх
- Ахицын үнэлгээ хийх
- Сурагчдын сонирхлыг дэмжих зорилготой шинэ үгийн болон түргэн хэллэгийн уралдаан зохион байгуулах үйл ажиллагааг цахиимаар зохион байгуулж бүх сурагчдыг хамруулан ажиллалаа.

### 5.2.5 Багшийн хөгжил рүү чиглэсэн англи хэлний мэргэшил, чадавхийг тасралтгүй дээшлүүлэх ажлын хүрээнд сургалтад хамрагдах



2021 оны 1 дүгээр сараас эхлэн англи хэлнийхээ багш А.Цэндмаа, Г.Саруул, С.Энхзаяа нарыг IELTS – ын шалгалтад бэлтгэх сургалтад хамруулж байна.

### **5.2.6 Сургалтын үзүүлэн, англи хэлний дүрмийн самбар байгуулах**

Дүйцсэн хөтөлбөрийн бага болон суурь боловсролын холимог бүлгийн 2 ангид шаардлагатай дүрмийн тайлбаруудыг сурагчдын түвшинд тохируулах нийт Англи хэлний идэвхтэй 12 цаг, Тоологдох болон тоологдохгүй нэрийн тайлбар, Харьцуулсан болон давуу зэргийн тайлбар, Байрлал болон цаг заасан угтвар үг, Заах төлөөний үгс, Захиран хүсэх төлөв, Дайвар үгс, Төлөөний нэр, Асуух үг гэсэн 12 багцаар 280 ширхэг хэрэглэгдэхүүн бэлтгэлээ.

### **5.3. Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний хөтөлбөр**

5.3.1 Иргэний эрх зүй улс төрийн боловсрол олгох сургалт, олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд боловсролын үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

Иргэний эрх зүй, улс төрийн боловсролын хүрээнд 88 удаагийн сургалтаар 2774 иргэнд сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулсан.

Жендэрт сүүрилсэн хүчирхийлэлтэй тэмцэх аяны хүрээнд “Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай” уриан дор олон нийт рүү чиглэсэн нөлөөллийн ажлыг 106 иргэнд зохион байгуулж ажилласан юм. Үүнд аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд иргэд олон нийтийн ойлголт хандлага мэдлэгийг дээшлүүлж жендэрт сүүрилсэн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд иргэн бүрийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль” зэргийг иргэдэд танилцуулах нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллалаа.

### **5.4. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр**

#### **5.4.1 Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх замаар амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх**

Зорилтот өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэхийн тулд тухайн өрхүүдийн гэр бүлийн гишүүдийн дунд судалгаа явуулж ажиллалаа. Үүнээс үзэхэд нийт 25 өрхийн 116 гишүүдээс хөдөлмөрийн насны -51 иргэн, 51 иргэнээс хөдөлмөр огт эрхэлдэггүй-24 иргэн, тухайн 24 иргэдээс мэргэжилгүй 13 иргэн байна гэсэн судалгаа гарсан бөгөөд эдгээр 13 иргэдтэй холбогдож манай байгууллагаар үйлчлүүлэн мэргэжил үнэ төлбөргүй эзэмшиж болохыг танилцуулав.

Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажил зуучлал хариуцсан мэргэжилтэн Н.Ганбаттай холбогдож 2021.05.24 ний өдрөөс өмнө мэргэжил эзэмшээгүй, ажил хийх сонирхолтой 18-35 насны иргэнийг ажилд зуучлахаар боллоо. Одоогоор 2 хүний саналыг аваад байна.

Мөн Хан-Уул дүүргийн 16-р хорооны халамжийн нийгмийн ажилтан П.Оюун, хөгжлийн нийгмийн ажилтан Ч.Одчулуу нартай хамтарч зорилтот өрхийн иргэдийг ажилтай болгох, мэргэжил боловсролгүй хүмүүсийг мэргэжил боловсролтой болгох зорилготой үйл ажиллагаануудыг төлөвлөж байна.

#### **5.4.2 Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг зорилтот өрхийн гишүүн бүрт оновчтой хүргэх**

Зорилтот өрхийн иргэдийг нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд жигд хамруулахын тулд гэр бүлийн гишүүдийн судалгааг шинэчлэн гаргалаа.

Судалгаанаас харахад 10 өрхийн 13 иргэнээс мэргэжлийн чиг баримжаа олгох оёдол эсгүүр 5, компьютерын сургалтад 5, үсчний сургалтад 2, солонгос хэлний сургалтад 3 нийт 15 иргэнийг хамруулав.

2021 оны 3 дугаар сард Хан-Уул дүүргийн 16-р хороотой хамтран Зорилтот өрхийн 25 иргэнд хүнсний тусламж тараахад хамтарч ажиллалаа.

### **5.4.3 Өрхийн гишүүдийн сөрөг зан үйл, дадал хэвшлийг өөрчилж гэр бүлийн эерэг таатай харилцааг төлөвшүүлэх**

Гэр бүлийн эерэг таатай харилцааг бий болгож сөрөг зан үйлийг багасгах зорилгоор архи, тамхины хор хөнөөлөөс сэргийлэх, гэр бүлийн таатай уур амьсгалыг хэрхэн бүрдүүлэх, хөл хорионы үед хүүхэдтэйгээ хэрхэн ажиллах, эцэг эхийн хоорондын харилцаа хүүхдэд хэрхэн нөлөөлдөг талаар 22 постер бэлтгэн хүргэлээ. Мөн архины хамаарал бүхий 22 иргэнд сургалт зохион байгуулав.

## **ЗУРГАА. “ХҮҮХЭД ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ” – ҮН ҮЙЛЧИЛГЭЭ**

**6.1 Хүүхэд хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлнэ.** 2021 оны 1 дүгээр сард Хүүхэд хамгааллын зөвлөлийн гишүүд хуралдаж төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Суралцагчдыг теле болон цахим хичээлд хамруулах чиглэлээр 2021 оны 01 сараас анги удирдсан багш нар ангийн групп нээж, сурагчидтай эргэх холбоотой ажиллалаа. Теле хичээлд хамрагдалтын судалгааг 7 хоног бүр дүүргийн Боловсролын хэлтэст хүргүүлж, хамрагдаж чадахгүй байгаа сурагчдад хэвлэмэл материал өгч ажилласан.
- “Дархлаагаа дэмжээд эрүүл байцгаая” сэдэвт PPT хичээлийг бэлтгэн ангийн цахим хаягаар дамжуулан хүргэлээ.
- Анги удирдсан багш нартай хамтран сурагчдын эрсдэлт бүлэгт байгаа сурагчид нөхцөл байдлын үнэлгээ хийж дүүргийн ГБХЗХ-тэй хамтран хамгаалах байранд байлгаж, дараагийн шатны байгууллагад сурагч Б.Ариунболдыг шилжүүллээ.
- Суралцагчдын эрсдэлийн үнэлгээг анги удирдсан багштай хамтран гаргаж цахим хурлаар дамжуулан суралцагчдын эцэг эхчүүдэд хандаж хүүхдийг эрсдэлгүй, эрүүл орчинд аюулгүй байлгах заавар зөвлөгөөг өгч ажилласан.
- 2021.01 сард цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Дүйцсэн хөтөлбөрийн ангийн 11 суралцагчийн ар гэрийнхэнд хүнсний тусламж үзүүллээ.



Зураг. 60



Зураг. 61

## **6.2 Хүүхэд, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх**

- Халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосонтой холбогдуулан хүүхдүүд гэртээ байх хугацаандаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сурагчдын эцэг эхчүүдтэй цахимаар болон утсаар холбогдож УОК, ДОК, Нийслэлийн боловсролын газар, байгууллагын багш ажилтнуудын гаргасан зөвлөмж мэдээллүүдийг тухай бүрт нь хүргэн ажиллаж байна.

- **2021 оны 3 дугаар сард багш сурагчдын ажиллах, суралцах орчинг сайжруулах зорилгоор** номын санд 35.000төг, бага ангид 76.000 төг, суурь боловсролын ангид 135.000 төг, компьютерын ангид 49.000 төг, нийт 295.000 төгрөгний тохижилтын ажлыг хийлээ.

- Суралцагчдыг ахуй орчиндоо галын аюулаас сэрэмжлүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газартай хамтран галын аюултай холбоотой мэдээ мэдээллийг сурагчдын ангийн группт байршуулж ажиллав.

- Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 22 сурагчийг 9 дүгээр сард Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Мөн вакцины судалгаа гаргаж вакцинд хамруулсан.

- Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хамрагдаж байгаа 22 сурагчдын ар гэрийн нөхцөл байдал, хүсэл сонирхлыг судлах зорилгоор ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.

- Анги удирдсан багш нараас сурагчдын мэдээллийг авч, сурагчидтай хийсэн ярилцлаган дээр тулгуурлан мэдээллийг шинэчлэн боловсрууллаа.

- Бага ангийн 11, суурь боловсролын 12 сурагчдын эцэг эх, асран хамгаалагчтай гурвалсан гэрээ байгуулаад байна.

## **6.3 Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх**

- 2021 онд захирлын тушаалаар” Байгууллагын эцэг эхийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, комиссын даргаар захирал Т.Рэгзэдмаа, гишүүдэд Гэр бүл, эрүүл мэндийн багш , Нийгмийн ажилтан нарыг томиллоо.Гишүүд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан 4 ажил төлөвлөн ажиллаж байна.

- Зөвлөлийн гишүүд байгууллагын ажилчдын судалгааг гаргаж, хүүхэдтэйгээ хэрхэн ажиллах, цахимын хор хөнөөлөөс хол байлгах, хөл хорионы үед гэрийн даалгаврыг хэрхэн хийлгэх талаар 3 удаагийн сургалт, 2 удаагийн уулзалт ярилцлага, 4 удаагийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

## **ДОЛОО. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ОРЧИН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ**

### **7.1 Насан туршийн чиглэлээр Эрх зүйн кабинет байгуулах**

Байгууллагын төлөвлөгөөнд 2021 оны 4 дүгээр улиралд кабинет байгуулахаар төлөвлөсөн ч Монгол Улсын хууль тогтоомжийн эмхэтгэл-267 ширхэг, Жаазтай сүлд-10000 төгрөг, Дэлхийн газрын зураг, Монголын газрын зурагтай самбар- 85500 нийт 95500 төгрөгийн тохижилт хийлээ.


### **7.2 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох кабинет байгуулах**

“Боловсролын тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 14.2.2, 14.2.3, дахь заалт, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-ний зорилт 1.1-ийн зорилт 1.1.4 дэх үйл ажиллагааг үндэслэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох

танхим байгуулах БШУ-ны сайдын тушаал батлагдан гарсны дагуу Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхим”-ыг байгуулж, 18 нэр төрлийн 45 ширхэг 18.993.870 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдлээ. Мөн 2300 ширхэг ном, гарын авлага нийлүүлэв.



Зураг. 62



Зураг. 63

Байгууллагын зүгээс Мэргэжил сонголтын талаар мэдээлэл өгөх 2 самбар 63000 төгрөгөөр хийж байршуулав.



Зураг. 64



Зураг. 65

### **7.3 Насанд хүрэгчдийн боловсролын хэрэгцээ онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж ашиглах**

#### **Хэрэгцээний судалгаа:**

Иргэдийн боловсролыг дээшлүүлэх, хэрэгцээг хангах, сонирхолд тулгуурлах, хөтөлбөрөө сайжруулах зорилгоор хэрэгцээний судалгааг авч ажиллалаа. 2021 онд хэрэгцээг насан туршийн боловсролын 6 чиглэл, мэргэжлийн чиг баримжаа олгох 6 чиглэлээр сургалтаар 55 удаа авч нийт 623 иргэн оролцлоо. Судалгааг дараах чиглэлээр авч, иргэдийн саналыг тусган сайжрууллаа.

#### **1 Хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх**

Иргэдээс ирсэн хэрэгцээний судалгаанд үндэслэн эхний хагас жилийн байдлаар 6 чиглэлийн 20 цагийн тогтолцоогоо 30%-иар өөрчилж хувилбарт хөтөлбөр боловсруулах, сургалтын албаны хурлаар хэлэлцэн, захирлаар батлуулан ажиллаж байна.



## 2 Заах арга зүйг дээшлүүлэх

Цахим орчинд богино хугацаанд чанартай сургалт явуулах арга зүйг эзэмшүүлэх сургалтыг 6 удаа зохион байгуулсан.

## 3 Сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах

Хичээлийн PPT-г хийхэд юуг анхаарах, өнгөний сонголтоо хэрхэн хийх талаар 2 цагийн сургалт зохион байгуулав.

## 4 Иргэдийн хүсэл сонирхлыг тусгах

Цахим орчинд онлайн сургалт, хурал зохион байгуулах Онлайн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүй /google meet, zoom, microsoft teams/


Үүлэн технологи /google docs, google sheets, google slides, google forms/ сургалтуудыг 12 газар явууллаа.

## Сэтгэл ханамжийн судалгаа


Багш нарын зохион байгуулсан сургалтад иргэдээс өгөх сэтгэл ханамжийг тандах, цаашид сургалтын үйл ажиллагаа сайжруулан иргэдэд хэрэгцээтэй, үр дүнтэй сургалт явуулах зорилгоор багш нар сургалт бүрийн дараа уг судалгааг авч хөтөлбөрөө сайжруулан ажилладаг.

2021 онд багш нар нийт 98 удаагийн сэтгэл ханамжийн судалгааг 956 хүнээс авч анализ хийн сургалтаа сайжруулан зохион байгуулж байна.

Судалгааг авахдаа багшийн заах арга зүй, харилцаа, хандлага, тухайн сургалтаас олж авсан мэдлэг, сайжруулах зүйл гэсэн чиглэлээр авч тухайн бүр анализ хийн ажилладаг.



Зураг. 66



Зураг. 67

Насанд хүрэгчдийн боловсролын хэрэгцээ онцлогт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж ашиглах талаар **2021 онд сургалтын 120 PPT , 2252 ш хэрэглэгдэхүүн, 15 зөвлөмж боловсруулан ажиллав.**

## 7.4 Дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтын агуулгыг суралцагчийн түвшин бүрт тохируулан боловсруулж, туршин хэрэгжүүлэх

• 2020-2021 оны хичээлийн жилд БСШУС-ын сайдын А/491, А/168 дугаар тушаалуудыг үндэслэн дүйцсэн хөтөлбөрийн 30 хүртэл хувийг агшаасан бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулан захирлын 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн А/33 тушаалаар баталгаажуулан хэрэгжүүлсэн бол 2021- 2022 оны хичээлийн жилд БШУЯ-ны сайдын 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/88 тушаалаар батлагдсан хөтөлбөрийг боловсрол нөхөн олгох ангиудад судлагдахуун бүрээр гарган, хэрэгжүүлэн ажиллаж байна. Мэргэжлийн багшаар 100% хангагдсан.

# НАЙМ. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ, МЭДЭЭЛЛИЙГ БҮХ ШАТАНД БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ


## 8.1 Байгууллагын веб хөгжүүлэх

• Байгууллагын веб хөгжүүлсэн байдал 2021 онд веб сайтын үйл ажиллагааны цэсийг хөгжүүлэхэд илүү чиглэн ажиллаж байна. Энэхүү хэсэгт байгууллагынхаа онцлог, сургалт зохион байгуулдаг багш ажилчдын мэдээллийг шинэчиллээ.

Ил тод байдлын үйл ажиллагааг веб хуудсанд дараах цэснүүдэд байршуулан цаг үедээ нийцүүлэн шинэчлэн сайжруулж байна. Үүнд:

- Хүний нөөцийн ил тод байдал
- Байгууллагын ил тод байдал
- Байгууллагын чиг үүрэг үзүүлэлт үнэлгээ
- Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ гэсэн 4 бүлэг хэсэгт хамааруулан байгууллагын төлөвлөгөө тайлан, зорилго, зорилт нээлттэй ажлын байр мэдээ, ёс зүйн дүрэм, хүний нөөцийн стратеги, хүний нөөцийн удирдлагын ил тод байдал, албан хаагчдын ажил гүйцэтгэлийг үнэлэх шалгуур, авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, худалдан авах үйл ажиллагааны ил тод, дэлгэрэнгүй байршуулдаг.

Байгууллагын веб хуудаст 2021 онд шинэчилсэн мэдээлэл



Зураг. 68



Зураг. 69


НАЙМ ТАНИЛЦУУЛАГА ҮЙЛ АЖИЛЛАГАА МЭДЭЭЛЭЛ ИЛ ТОД БАЙДАЛ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ

### Ёс зүйн зөвлөлийн 2021 оны төлөвлөгөө

БАТАМ ХАН УИД ДУРГИЙН АЛБАН БИС НЭСНИЙ ТУШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВЛИЙН ХӨНӨЛӨГӨӨ

№	Зорилт	Үйл ажиллагаа	2021 оны I дугаар сарын												Хяналт	
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
1	Ёс зүйн зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөг батлуулах															
2	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
3	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
4	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
5	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
6	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
7	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
8	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
9	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
10	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
11	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															
12	Сүхбаатар дүүргийн агаарын богиносгоны төлөвлөгөөг батлуулах															

Хүснэгт. 1



Зураг. 68

## 8.2 Байгууллагын пэйж-ийг хөгжүүлэх

Байгууллагын пэйж-ийг хөгжүүлсэн байдал- Байгууллагын бүхий л ажлын үйл явцын мэдээллийг цаг тухай бүрт нь пэйж хуудсанд байршуулан, хуваалцаж түгээн ажиллаж байна. Одоогийн байдлаар 3493 дагагчтай байгаа нь 12 сартай харьцуулбал дагагчдын тоо 805-аар өслөө. Одоогоор байгууллагын пэйж хуудсанд

- Цаг үеийн постер-122
- Цахим сургалтууд-33
- Контент цуврал хичээлүүд-37
- Боловсрол хэлтэс хамтарсан Лайв хичээл-5
- Олон нийт үйл ажиллагаа – 5 байршсан бөгөөд 40000 гаруй хандалттай байна.

## 8.3 Боловсролын салбарын мэдээллийн системд хүсэлт гаргасан сурагчдыг бүртгэж баталгаажуулах /esis.edu.mn/

2020-2021 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол эзэмших хүсэлт гаргасан бага ангид-1, суурь боловсролд-5, бүрэн дунд боловсрол-21 нийт 27 иргэний материалыг хүлээн авч Нийслэлийн Боловсролын газар, БШУЯ-д хүргүүлж, баталгаажилт хийлгэн, элсэлт төгсөлтөө хийгээд байна.

2021-2022 оны хичээлийн жилд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмших хүсэлт гаргасан 23 иргэнийг материалыг хүлээн авч НБГ болон БШУЯ-д хүргүүлж ажиллалаа.

## 8.4 ТАХ-ын мэдээг үнэн зөв гаргах

2021 онд ажлаас чөлөөлөгдсөн- 9, жирэмсний амралттай 1 иргэн, шинээр ажилд орсон 9 иргэнийг хүний нөөцөд бүртгэж, мэдээг цаг хугацаанд нь гаргаж илгээсэн.

## 8.5 Байгууллага дээрх ДХШҮ-ний ажлыг зохион байгуулах

2021 оны захирлын А/08 тоот тушаалаар байгууллагын ДХШҮ-ний багийг шинээр томилж, томилогдсон гишүүд 2021 онд ажиллах төлөвлөгөө гарган, батлуулав.

ДХШҮний баг нь 11 удаагийн ХШҮ-г хийж зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

БАТЛАВ  
ХАН-УУЛДУРГИЙН  
АЛБАН БУС-НАСАН ТУВЧИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ *М. Сүхбаатар* Т.РЭГЭЭДМАА

2021 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажилууд	2021 он сар												Гүйцэтгэлийн хувь	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
1.	Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, хуваарь батлуулах														
2.	Батлагдсан төлөвлөгөө, хуваарийг танилцуулах														
3.	ЗГ-ын 2017 оны 99-р тогтоолыг танилцуулах, сургалт зохион байгуулах														
4.	Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгөх, тайлагнах														
5.	Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхэд үнэлгээ хийх														
6.	Ажилтнуудын сар, улирал, хугаца бүтэн жилийн тайланг судлах														
7.	Сарын ажлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх /гүүвэрээр/														
8.	Багш нарын хичээлд сууж хяналт, үнэлгээ хийх, зөвлөмж өгөх														
9.	Хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх														
10.	Байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлж ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах														
11.	Арсан материал хүлээлгэн өгөх														

Төлөвлөгөө боловсруулсан: ДЭД ЗАХИРАЛ *М. Сүхбаатар* ЖОЮУНДЭЦЭГ

Хүснэгт. 2

Ажлын байрны тодорхойлолтод дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Нийгмийн ажилтан-сэтгэл судлаач, бага боловсролын багш, Бие дааж боловсрол дээшлүүлэх үйлчилгээний багш, нярав, нягтлан нарын тодорхойлолтыг дахин шинэчиллээ. Цаашид жил, сарын ажлын төлөвлөгөөг албан хаагч бүр ажлын байрны тодорхойлолтод

тусгагдсан үндсэн ажил үйлчилгээгээр боловсруулж, хэрэгжилтийг тайлагнах нь зүйтэй гэж үзсэний дагуу багш, ажилчид сар, жилийн ажлын төлөвлөгөөгөө ажлын байрны тодорхойлолтын дагуу хийж байна.

Мөн байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр явууллаа.

ТАЙЛАН БИЧСЭН

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

О.МЯГМАРСҮРЭН

ТАЙЛАНГ ХЯНАСАН

ЗАХИРАЛ

Т.РЭГЗЭДМАА